



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.30 № 01/587
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНЫ
ДАРГАД. ОТГОНБАЯР ТАНАА

Сонгуулийн мэрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мэрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мэрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мэрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мэрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит

сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (8 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

РЭНЧИНЛХУМБЭ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Төрийн албыг хариуцлагатай, чадавхтай болгох албан хаагчдын харилцаа, хандлагыг өөрчлөх, цахим засаглалд шилжүүлэх иргэдээ сонсож иргэндээ ойртсон төрийн үйлчилгээг нэвтрүүлж хүнд суртал, авлига улс төрөөс ангид төрийн албыг бий болгож салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж бүх талаар нь дэмжин ажилдана.

НЭГ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 1.1. Төрийн үйлчилгээнд "Цахим засаглал"-ыг нэвтрүүлж, иргэдийг цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.
 - 1.1.1. "Нэг иргэн-Нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг хэрэгжүүлж ажиллана.
 - 1.1.2. Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулж байгуулж, шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
 - 1.1.3. Нээлттэй хаалганы өдрийг жилд 2 удаа зохион байгуулна.
 - 1.1.4. Төрийн үйлчилгээний бүх салбарт авлигыг таслан зогсоох хөтөлбөр хэрэгжүүлж, төрийн байгууллага иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.
 - 1.1.5. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгана.
 - 1.1.6. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, "Архигүй, Улс төргүй төрийн алба" аян арга хэмжээг зохион байгуулж, төрийн алба хаагчдад хүлээлгэх хариуцлагыг чангатгана.
 - 1.1.7. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулж, төрийн албан хаагчийн сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэн шаардлагад нийцсэн сургалтын орчин бий болгоно.
 - 1.1.8. Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох, үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендерийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.
 - 1.1.9. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж улс тэр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана.
 - 1.1.10. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, үр нөлөөг дээшлүүлэн гүйцэтгэлээр үнэлж, хариуцлагыг сайжруулна.
 - 1.1.11. Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалт, орчин нөхцөлийг сайжруулна.
 - 1.1.12. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод, байдлыг нэмэгдүүлж 4 дэх засаглалыг бэхжүүлж, Хэвлэл мэдээллийн багийг томилон ажиллуулж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангана.
 - 1.1.13. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг сайжруулж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай хүргэн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

т, орчин нөхцлийг сайжруулна
ааны мэдээллийн ил тод бар
влэл мэдээллийн багийг том
на.

чанарыг сайжруулж, олон н
орх зүйн боловсролыг дээшлүү

1.1.14. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.

1.1.15. Цэрэг иргэний хамгаалалтын бодлогыг дэмжин орон нутагтаа үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллана.

1.1.16. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэн тодотгоно.

1.1.17. "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэн олон талт арга хэмжээг хэрэгжүүлж хугацаат цэргийн алба хаах иргэдийн идэвхийг нэмэгдүүлнэ.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНД, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН БОДЛОГО

Эрүүл Иргэн

2.1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүrtээмжийг сайжруулна.

2.1.1. Гэр бүл, байгууллага, багт эрүүл аюулгүй орчин бүрдүүлнэ.

2.1.2. Урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс чухал аян арга хэмжээг өрнүүлнэ.

2.1.3. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүrtээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг улсын жишигт хургэнэ.

2.1.4. Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх хянах, эрт илрүүлэх тогтолцоог орон нутгийн түвшинд шинэчилж, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.

2.1.5. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, "AAA" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.6. Эмнэлгийн болон яаралтай тусlamж үйлчилгээний чанар, хүrtээмжийг сайжруулан иргэд орон нутагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.1.7. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөрт хамрагдан эм хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

2.1.8. Нөхөн үржихүйн тусlamж, үйлчилгээний чанар, хүrtээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэл нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.

2.1.9. Малчдын нярай хүүхдийг тогтмол эргэж, асаргааны зөвлөгөөг тогтмолжуулж, нярайн эндэгдлийг бууруулна.

2.1.10. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, сургалт, мэргэшил, үр чадварыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж, нийгмийн болон хөдөлмөр хамгааллыг сайжруулан, ёс зүй, харилцаа, хандлагыг өөрчилж, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.


2.1.11. Эрүүл зан үйлд хүүхэд залуусыг сургах "Эрүүл мэндийн клуб" ажиллуулна.

2.1.12. Шүдний эмчтэй болж, техник тоног төхөөрөмжээр хангаж, шүдний кабинеттaiй болно.

2.1.13. Гэрээр эмийн сан аялуулах үйлчилгээг нэвтрүүлнэ.

2.1.14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндэд тусгайлан анхаарч ажиллана.

2.1.15. Өсвөр үеийн хүүхэд залуучуудыг эрүүл зан үйл, дадал хэвшилд сургах



Очир

000000000?

арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.16. Нөхөн сэргээх Физик эмчилгээг шинээр нэвтрүүлж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.

2.1.17. Багт хүрч үйлчилье арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.1.18. Ахмад настан, бага насны хүүхдийн эрүүл мэндэд онцгойлон анхаарч ээлж дараалалгүй үйлчилнэ.

2.1.19. Иргэн бүрийг амбулаторид хамруулна.

2.1.20. Эмчийн заавраар хөнгөлөлттэй эмийн үйлчилгээ авах иргэдэд үйлчлэх эмийн сангийн эм тарианы хангамжийг нэмэгдүүлнэ.

Хамгаалагдсан иргэн

2.2. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй хүндэрэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.1 Дээд шатны байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдлыг дэмжих, тодорхой хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлтэд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн нөхцөл боломжид тулгуурлан хамтран зохион байгуулна.

2.2.2 Зорилтот бүлгийн өрх, иргэнд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг бодит судалгаанд үндэслэн тухайн иргэнд хүргэж ажиллана.

2.2.3 Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин, цаг үеийн нөхцөл байдлыг үл харгалзан тогтмол ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, ажлын байрыг хамгаалах, орлогыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.4 Хүнсний нөөцийн судалгааг тухай бүр гарган, шаардлагатай үед нэмж бэлтгэх, татан төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, “Нутгийн бүтээгдэхүүн – Нийтлэг хэрэглээ” уриаг дэвшиүүлж хэрэгжүүлнэ.

2.2.5 “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж бэлэн байдлыг хангах, шаардлагатай хүн хүч нөөц хэрэгслийн бэлэн байдлыг тогтмол хамган ажиллана.

2.2.6 “Хамгаалагдсан Хөвсгөл” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

2.2.7 Хяналтын пост ажиллуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангаж шаардагдах төсөв хөрөнгийн нөөцийг бүрдүүлэх.

2.2.8 Эрсдэлтэй бүс нутгаас ирсэн болон өвчний шинж тэмдэг илэрсэн иргэдийг байршуулах тусгаарлах байрыг бэлтгэж шаардлагатай хугацаанд байнгын бэлэн байдалд байлгана.

2.2.9 Гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгож, тохиолдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.


2.2.10 “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх вакцинд иргэдийг, улирлын томуугийн вакцинд сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг бүрэн хамруулна.

2.2.11 Иргэдэд хандсан зэрэг, зөв мэдээллийг түгээх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө болон гэр бүлээ хамгаалах ойлголт, арга ухаанд сургаж цахим болон зайн хэлбэрийн сургалт, мэдээллийг зурагт, интернэтгүй өрх, хүн амд хүргэх боломжийг нэмэгдүүлнэ.

Нийтийн биеийн тамир

2.3. Нийтийн биеийн тамир, мэргэжлийн спортын дэмжиж зэлтэй орчныг бүрдүүлнэ.

2.3.1. Байгууллага хувь хүн иргэн аж ахуйн нэгжид нийтийн биеийн тамирын



0000000003

хуваарь гаргаж, цаг тогтоож, спорт заалны орчин нөхцөлийг сайжруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.3.2. Тив, дэлхий, олимпын наадамд өндөр амжилт үзүүлж буй спортын төрлүүдийг хөгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг бэлтгэж чадавхжуулна.

2.3.3. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшил спортын холбоодын түншлэлийн менежментийг хэрэгжүүлж, амжилтад суурилсан урамшуулалт олгоно.

2.3.4. Соёл, спортын цогцолборыг ашиглалтад оруулж, спортын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлнэ.

2.3.5. Бүсийн сумдын залуучуудын спортын наадмыг зохион байгуулна.

2.3.6. Сумын чийрэгжүүлэлтийн танхимын үйл ажиллагааг тогтмолжуулж, мэргэжлийн багшаар хангана.

2.3.7. Багуудын бага олимпыг жил бүр зохион байгуулна.

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛЫН БОДЛОГО

Эрдэмт Монгол хүн

3.1. Боловсролын салбарын хүний нөөцийн чадварыг дээшлүүлж, сургалтыг чанаржуулан ажиллана.

3.1.1. Хөгжсөн багш-Хөгжсөн сургач хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, сургалтын чанарыг сайжруулж, амжилт гаргасан багш сургачдыг урамшуулна.

3.1.2. Монгол бичгийн хичээлийн агуулгыг сайжруулж тусгайлан анхаарч бодлогоор дэмжиж ажиллана.

3.1.3. Боловсролын үйлчилгээний тэгш байдлыг хангаж, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

3.1.4 Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын байгууллагын үйлчилгээнд бүрэн хамруулна.

3.1.5 Орон нутгийн боловсролын бодлого, төлөвлөлтийг оновчтой болгон, удирдлагын менежментийг сайжруулна.

3.1.6 Сумын Засаг даргын нэрэмжит олимпиад болон ахмад багш нарын нэрэмжит массын олимпиадыг зохион явуулж, шагнал урамшууллын асуудлыг шийднэ.

3.1.7 Хүүхэд, залуучууд, иргэд, төрийн албан хаагчийн гадаад хэл, цахим боловсролын түвшнийг ахиулж хэрэглээг нэмэгдүүлнэ.

3.1.8 Хөдөөгийн багуудад жил бүрийн 4-6 дугаар сард "Хүрч үйлчилье" өдөрлөг арга хэмжээг зохион байгуулна.

3.1.9 Боловсролын байгууллагын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, дэмжин урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.10 Боловсрол дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.


3.1.11 Хөрөнгө оруулалтыг боловсролын үйлчилгээний стандарт, хүртээмжтэй уялдуулан төлөвлөж хэрэгжүүлнэ.

3.1.12 Орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ХИМИ, БИОЛОГИ, МЭДЭЭЛЭЛ ЗҮЙ, ГАДААД ХЭЛ-ны лабораторитой болгоно.

3.1.13 Бусад суманд суралцаж байгаа сургачдаа сумандаа суралцах нөхцөл боломжоор хангана.

Соёл – Дархад ястны өв

3.2. Эх хэл, соёл, өв уламжлалаа дээдэлсэн эх оронч үзэлтэй, эв нэгдлийг



0000000004

эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлж, соёл урлагийн чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

3.2.1. Иргэд залуучуудын дунд соёл урлагийн арга хэмжээг 14 хоног тутамд зохион байгуулж ажиллана.

3.2.2. Хөдөөгийн багуудад сар бүр соёл урлагийн арга хэмжээг зохин байгуулж хэвшина.

3.2.3. Дархад аман аялгуу, нутгийн онцлог бүхий дахин давтагдашгүй соёлын биет ба биет бус өвийг хадгалж хамгаалах, өвлүүлэх, соёлын үл хөдлөх дурсгалын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулна.

3.2.4. Соёл, өв уламжлалын аялал жуулчлал, соёлын бүтээл, үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.5. Дархад дуу өв сан хөтөлбөр гарган хүүхэд, залуусыг Дархад дуу дуулж сурлах ажлыг зохион байгуулж, өв сан байгуулж, цахимд байршуулна.

3.2.6. Угийн бичиг хөтлөх арга зүйг нэвтрүүлэн ураг тээхнээр бүртгэлжүүлэн хэвлүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2.7. Орон нутаг дахь соёлын өвийг хамгаалах алдаршуулах ажлыг зохион байгуулна.

3.2.8. Дархад ястны өв соёл, газар нутгийн онцлог, сумаас төрөн гарсан алдартан, түүхэн ховор олдвор зэргийг багтаасан сум судлах музей бий болгоно.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БОДЛОГО

4.1. Төсөв санхүүгийн үйл ажиллагаанд оновчтой бодлогыг тодорхойлж, нийгмийн хөгжлийн зорилт хэрэгжихүйц, иргэдийн оролцоотой, ил тод, хариуцлагатай төсвийн орчныг бүрдүүлнэ.

4.1.1. Төсвийн төлөвлөлт, хуваарилалт, үйл ажиллагааг чанаржуулж, ил тод болгоно.

4.1.2. Санхүүгийн ажилтнуудын мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, ажиллах нөхцөл боломжоор ханган, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийнэ.

4.1.3. Аж ахуйн нэгжүүдийн бүртгэл мэдээллийг шинэчлэн, санхүүгийн тайлагналтын хувь хэмжээ, чанарыг улсын дунджаас бууруулахгүй ажиллана.


4.1.4. Татварын үйлчилгээг 100 хувь цахим болгож, татварын алба болон татвар төлөгчдийн цаг хугацаа, эдийн засаг, бусад хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэнэ.

4.1.5. Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг хуульд заасан хувь хэмжээгээр нэмэгдүүлж татвар төлөгчдийн эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

4.1.6. Төрийн байгууллагуудын дотоод хяналтаар санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх чадавхыг бий болгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шат ахисан сургалт явуулах, эрсдэлийг анхан шатанд удирдан, зөрчлийн хувь хэмжээг бууруулна.

4.1.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын хүний нөөцийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, программ хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, ногоон худалдан авалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

4.1.8. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, зээл тусlamжийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нийлүүлэлт, бүтээн байгуулалтын гүйцэтгэлд дотоод болон хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмол явуулах замаар төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.




000000005

4.1.9. Орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийг сайжруулах замаар өмч бэлтгэх, төлөвлөх ажиллагааг боловсронгуй болгож, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.

Жижиг, дунд үйлдвэрлэл

4.2. Орон нутгийн онцлог, нөөц, мэдлэгт сууриссан жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэн баялаг бүтээгчдийг бизнесийн таатай нөхцөлөөр хангаж, тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлнэ.

4.2.1. Бүх төрлийн зээлийн сан, эх үүсвэрийг оновчтой төлөвлөж, баялаг бүтээгч, бизнес эрхлэгчдэд бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

4.2.2. Мал аж ахуйн түүхий эдийн цэгийг байгуулж, үнэ цэнийг өсгөж, арьс ширэнд анхан шатны боловсруулалтыг хийж, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангана.

4.2.3. Орон нутгийн хөгжилд нөлөөлөхүйц бие даасан эдийн засгийн чадамжтай томоохон үйлдвэрлэлүүдийг байгуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

4.2.4. Баялаг бүтээгчид бизнес эрхлэгчдийг дэмжиж чадавхжуулах сургалтыг шат дараатай зохион байгуулна.

4.2.5. ЖДҮ эрхлэгчид болон баялаг бүтээгчдийн үйл ажиллагааг дэмжиж үзэсгэлэн худалдааг жилд 1 удаа зохион байгуулна.

4.2.6. Өрх бүрийн бичиг бизнесийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ.

Нийгмийн хамгааллын үйлчилгээ

4.3. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, нийгмийн хамгааллын үйлчилгээг, ил тод, шуурхай, хүртээмжтэй болгон цахим үйлчилгээг өргөжүүлнэ.

4.3.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангаж, нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг сайжруулна.

4.3.2. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт оновчтой хүргэж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

4.3.3. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлнэ.

4.3.4. Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлж, тэтгэвэр тэтгэмжийг хуулийн хугацаанд олгож сангийн мэдээлэл, тайланг ил тод болгож, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

4.3.5. Малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж тэдний нийгмийн баталгааг хангана.

4.3.6. Шүүх, цагдаа, прокурорын байгууллагыг суманд жилд 1 удаа ажиллуулж, иргэдийн санал хүсэлтийг газар дээр нь шийдвэрлүүлнэ.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, МАЛ АЖ АХУЙН БОДЛОГО


5.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.

5.1.1. "Хариуцлагатай нүүдэлчин" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, мал аж ахуйн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

5.1.2. Бэлчээрийн зохистой менежментийн дэд хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

5.1.3. "Цахим мал эмнэлэг" нэгдсэн системийг хэрэгжүүлнэ.

5.1.4. Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийт эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй тайван бус нутгаа баталгаажуулна.



0000000006

- 5.1.5. Мал тарилгын хашааг стандартын дагуу шинээр бариулна.
- 5.1.6. Малын үүлдэр угсааг сайжруулах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 5.1.7. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор өрсөлдөөнийг бий болгоно.
- 5.1.8. Малчдын малын хашаа хороо сэлбэх шинээр барихад бодлогоор дэмжиж боломжийг бий болгоно.
- 5.1.9. Мал эмнэлгийн сургалт сурталчилгааг бүх багт зохион байгуулах.

Газар тариалан - Ногоон хүнс

5.2. Газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжин дотоодын зах зээлийг хамгаалж, хүн амын хэрэгцээг бүрэн хангана.

5.2.1. Газар тариалангийн салбарт шинэ нэр төрлийг нэмэгдүүлж, техникийн хангамжийг сайжруулан хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэн иргэн ахуйг дэмжиж, дотоодын зах зээлийг бий болгоно.

5.2.2. Төмс хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэн газар нутгийн онцлогт тулгуурлан дэмжиж, бүтээмжийг нэмэгдүүлэн хүн амын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.

5.2.3. "Жимс, жимсгэнэ" хөтөлбөрийг хэрэгжүүлж, нэр төрлийг нэмэгдүүлж буй иргэн хуулийн этгээдийг бодлогоор дэмжиж ажиллана.

5.2.4. Газар тариалангийн хадлангийн салаатай болно.

ЗУРГАА. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ-ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

6.1 Аялал жуулчлалд оролцогч талуудын хамтын ажиллагаанд тулгуурлан "Тогтвортой аялал жуулчлал-Гадаад харилцаа"-г хөгжүүлнэ.

6.1.1. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл"-ийг орон нутагт хэрэгжүүлж, нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлж, дэд бүтцийг байгаль орчинд ээлтэй байдлаар шийдвэрлэнэ.

6.1.2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, стандартыг сайжруулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

6.1.3. Орон нутгийн онцлогт нийцсэн шинэлэг, брэнд бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, гадаад улс орнуудад сурталчилж аялал жуулчлалыг дэмжинэ.

6.1.4. "Цахим аялал жуулчлал" арга хэмжээний хүрээнд гадаад, дотоод сурталчилгааг тусгайлан бодлогоор зохион байгуулна.

6.1.5. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг гадаад, дотоод улс орнуудад сурталчилж, жилд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

6.1.6. Хил орчмын аялал жуулчлалыг өргөжүүлэн хөгжүүлнэ.

6.1.7. Хөвсгөл нүүр, Дархадын хотгорын эко аялал жуулчлалыг бодлогоор орон нутагт дэмжин хөгжүүлнэ.

6.1.8. Гадаад орнуудын хот, мужуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, эдийн засаг нийгмийн тэргүүлэх салбаруудын хүний нөөцийг сургах дадлагажуулах туршлага солилцон ажиллана.

6.1.9. Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүтэй хамтран хэрэгжүүлэх, үйл ажиллагааны чиглэлийг өргөтгөнэ.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

7.1. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.

7.1.1. Улсын хил дамнасан ойн түймрээс сэргийлэх, тэмцэх талаар хөрш



